

ТҮҮХИЙ НҮҮРС ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 2 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 62

ТҮҮХИЙ НҮҮРС ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ

Агаарын тухай хуулийн 16.1.5-д заасныг үндэслэн Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2018 оны 2 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглосугай.2.Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20, Сонгинохайрхан дүүргийн 21, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэр энэ тогтоолын 1 дүгээр зүйлд хамаарахгүй байхаар тогтоосугай.3.Боловсруулсан түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх, түлшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах асуудлыг судалж 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд нарт тус тус даалгасугай.4.Энэ тогтоолын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх, тайлбарлах, сурталчлах ажлыг зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Н.ЦЭРЭНБАТ

Засгийн газрын 2017 оны 98 дугаар
тогтоолын хавсралт

АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Улаанбаатар хотын хүн ам өсч, төвлөрөл нэмэгдэж байгаагийн улмаас хүрээлэн байгаа орчны бохирдол ихэсч, энэ нь байгаль орчин төдийгүй улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил, хүний амьдрах орчин, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот төдийгүй аймгийн төвүүдийн агаарын бохирдол нэмэгдэж, ялангуяа өвлийн улиралд Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжээ (нийт ажиглалтын 50 гаруй хувьд Монгол Улсын Агаарын чанарын стандартаас давж) хэт ихэсч, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 хувийг гэр хорооллын айл өрхийн гэрийн зуух болон аж ахуйн нэгж, байгууллагын 3200 орчим халаалтын зуух, 10 хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа 400 мянга гаруй автотээврийн хэрэгсэл, 5-6 хувийг дулааны цахилгаан станцууд, 4 хувийг үнсэн сан, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал зэрэг бусад эх үүсвэр ялгаруулж байна.

Усны бохирдлын гол эх үүсвэр нь цэвэрлээгүй болон дутуу цэвэрлэсэн үйлдвэрлэлийн болон ахуйн бохир ус, стандартын шаардлага хангахгүй ариун цэврийн байгууламж, хог хаягдал, хөрс болон агаарын бохирдол, уул уурхайн болон барилгын үйлдвэрлэлээс үүдэлтэй лаг шавар, хагшаас зэрэг байна.

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон хот, суурин газрын цэвэрлэх байгууламж нь техник, технологийн хувьд хоцрогдож, хүчин чадал нь ачааллаа даахгүй болж, усны бохирдлын гол эх үүсвэр болоод байна.

Улсын хэмжээний нийт 130 гаруй цэвэрлэх байгууламжийн талаас илүү нь үйл ажиллагааны доголдол, эвдрэлтэй байгаагаас жилд 120 сая гаруй шоометр бохир ус байгальд хаягдаж, Туул, Хараа, Орхон, Хангал зэрэг голын усыг эрдэс болон органик бодисоор бохирдуулж байна.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усны нөлөөгөөр Туул голын ус Сонгины гүүрээс Төв аймгийн Алтанбулаг сум хүртэлх хэсэгт “маш бохир” гэж үнэлэгдэж, усан дахь органик бодисын агууламж Усны чанарын стандартаас 2-266 дахин, аммонийн азот стандартаас 1.4-61 дахин илүү бохирдсон байна.

Улаанбаатар хотын гэр хороолол тэлэхийн хэрээр стандартын шаардлагад нийцэхгүй, доторлогоогүй ариун цэврийн байгууламж нэмэгдэж байгаа нь ус, хөрсний бохирдлын гол эх үүсвэр, халдварт өвчин дэгдэх суурь нөхцөл болж байна. Улаанбаатар хотын гэр хорооллын 190 мянга гаруй өрхийн ариун цэврийн байгууламжийн 80 хувь нь стандартад нийцэхгүй байна.

Хөрсний бохирдлын гол эх үүсвэр нь гэр хорооллын ариун цэврийн байгууламжаас гадна хог хаягдал, уул уурхайн хаягдал, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн хаягдал, агаарын бохирдлоос үүдэлтэй байна.

Улаанбаатар хотын хөрсний бохирдлыг экогеохимийн судалгаагаар 360 цэгээс сорьц авч шинжлэхэд 88.0 хувьд нь нян, хөгц мөөгөнцөр илэрсэн байна.

Хот, суурин газарт гэр хорооллын ариун цэврийн байгууламжаас (жорлон, муу усны нүх) хамааралтай нянгийн бохирдол өндөр байдаг бол орон нутагт уул уурхайн үүдэлтэй хөрсний бохирдол их байна. Боловсруулах үйлдвэр, машин засварын газар, хогийн цэгийн орчмын хөрсөнд хар тугалга, хром, цайр зэрэг хүнд металлын бохирдол ихээр илэрч байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах хүрээнд хийгдэж байгаа ажлууд үр дүн багатай байгаагаас хотын хүн ам, ялангуяа хүүхэд, өндөр настны дунд агаарын бохирдлоос шалтгаалсан амьсгалын замын өвчлөл улам ихэсч, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учруулж байна.

Иймд агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ойрын хугацаанд үр дүнд хүрэх, бодитой үйл ажиллагааг тодорхойлсон нэгдсэн бодлого боловсруулж, техник, технологи, хөрөнгө санхүү, хүний нөөцийн бүхий л боломжийг ашиглан салбар дундын нэгдсэн зохицуулалтыг ханган хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх” зорилтыг дэвшүүлж, агаарын бохирдлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1. хот төлөвлөлт, байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлэх замаар төвлөрлийг сааруулан хот, суурин газрын агаар, орчны чанарыг сайжруулах;

2.2.2. байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах;

2.2.3. автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулах бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах;

2.2.4. агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт, санхүүжилтийг тодорхой болгож, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг урамшуулах тогтолцоог бий болгох;

2.2.5. орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

3.1. Хөтөлбөрийг 2017-2025 онд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.1.1. нэгдүгээр үе шат: 2017-2019 он;

3.1.2. хоёрдугаар үе шат: 2020-2025 он.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Хот төлөвлөлт, байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлэх замаар төвлөрлийг сааруулан хот, суурин газрын агаар, орчны чанарыг сайжруулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.1.1. хүн амын суурьшлын ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, бүс нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар нийслэлийн хүн амын төвлөрлийг зогсоох;

4.1.2. нийслэлд шилжин ирэх хөдөлгөөнийг хязгаарлаж, нийслэлийн гэр хорооллын тэлэлтийг зогсоож, яндангийн тоог нэмэгдүүлэхгүй байх;

4.1.3. нүүлгэн шилжүүлэлт, дахин төлөвлөлтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, ачаа тээврийн төмөр зам, хурдны авто замын төсөл хэрэгжүүлэх;

4.1.4. төрийн байгууллага, их, дээд сургуулийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэх асуудлыг судалж, зохион байгуулах;

4.1.5. хөрөнгө оруулалтыг орон нутаг руу чиглүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ хэрэгжүүлж, орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх;

4.1.6. цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ, дэд станцыг өргөтгөн хүчин чадлыг нь нэмэгдүүлж, гэр хорооллын айл өрх 2.5-4кВт хүчин чадалтай цахилгаан халаагуур ашиглах техникийн боломжийг бүрдүүлэх;

4.1.7. “Хямд өртөгтэй орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гэр хороололд амины орон сууцыг барихад чиглэсэн дэд бүтцийг байгуулж, орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх, залуучууд, бага, дунд орлоготой иргэдийг урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах;

4.1.8. төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн инженерийн хангамжид холбох, дэд төвүүдийг байгуулах, сэргээгдэх эрчим хүчний технологи нэвтрүүлэх;

4.1.9. Улаанбаатар хотод ажиллаж байгаа халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчийг төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн хангамжид үе шаттайгаар холбох;

4.1.10. хот, суурин газрын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй болгох;

4.1.11. арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэр, авто техникийн болон барилгын материалын захыг нийслэлээс үе шаттай нүүлгэн шилжүүлж, инновацид тулгуурласан ногоон технологи бүхий үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх;

4.1.12. хот, суурин газрын орчимд элс, хайрганы олборлолт, үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хязгаарлаж, газрыг нөхөн сэргээх;

4.1.13. гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар хот, суурин газрын ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлэх;

4.1.14. Туул гол, түүний цутгал Сэлбэ, Улиастай, Баянгол, Зүүн салаа, Баруун салаа, Толгойт зэрэг голуудад хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлж, үерийн далан болон хамгаалалтын бүсэд буусан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг нүүлгэх бэлтгэл ажлыг хангаж, үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх.

4.2. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.1. хот, суурин газрын “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг шинэчлэн тогтоож, халаалтын зориулалтаар шатааж хэрэглэхийг хориглох зүйлсийн жагсаалтыг гарган мөрдүүлэх;

4.2.2. дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрсийг үе шаттайгаар хориглох;

4.2.3. гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг дэмжин түүхий нүүрсний хэрэглээг орлуулах;

4.2.4. гэр хорооллын 2 тарифт тоолууртай айл өрхийн шөнө хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50.0-100 хувь хөнгөлөх;

4.2.5. байгальд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи бүхий барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн зохицуулалт бий болгож хэрэгжүүлэх;

4.2.6. гэр, байшингийн дулаалгыг сайжруулж, дулааны алдагдлыг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.2.7. хот, суурин газрын дулааны хангамж, шугам сүлжээг өргөтгөх, шинээр дулааны эх үүсвэр барих ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, нүүрсний хэрэглээ, хаягдлыг бууруулахад чиглэсэн технологийн шинэчлэл хийх;

4.2.8. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон бусад хот, суурин газрын ариутгах татуургын байгууламж, үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор шинэчлэх;

4.2.9. гэр хорооллын айл өрхийн үнс, хог хаягдлыг хадгалах зориулалтын цэг болон хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх машин механизмын тоог нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хог хаягдлыг ашиглах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих;

4.2.10. аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалттай байгууламж байгуулж, аюултай хог хаягдал хяналтгүй тархах байдлыг хумих;

4.2.11. ашиглалтаас гарсан сав, баглаа боодол, зай хураагуур, аккумулятор, өдрийн гэрлийн шил, элэгдсэн дугуй, ажилласан тос зэрэг хог хаягдлыг үйлдвэрлэгч, импортлогч, борлуулагч нь хариуцаж эргүүлэн татах зохицуулалт болон тэдгээр хаягдлыг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн тохиолдолд олгох урамшууллын тогтолцоог бий болгох;

4.2.12. нүүрсний давхаргын метан хийн нөөцийн судалгааг эрчимжүүлж, нүүрс баяжуулах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах үйл ажиллагааг дэмжих;

4.2.13. хот, суурин газрын нутаг дэвсгэрт түүхий нүүрс хэрэглэхийг зогсоох бодлогын хүрээнд зорчигч суудлын галт тэргийг цахилгаан халаалтад үе шаттай шилжүүлэх;

4.2.14. үйлдвэрлэл, үйлчилгээнээс үүссэн орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах, байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашиглахад чиглэсэн стандартуудыг шинэчлэн тогтоож мөрдүүлэх;

4.2.15. агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийг бууруулах инновацийн судалгаа, технологийн хөгжлийг дэмжин санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлэх, олон улсын сангуудаас санхүүгийн дэмжлэг авахад дэмжлэг үзүүлэх;

4.2.16. агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологийг олон нийтэд таниулах “Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв”-ийг байгуулах;

4.2.17. “Ногоон зээлийн сан” байгуулах асуудлыг судалж, иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгальд ээлтэй, агаар, орчны бохирдол болон дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, цахилгаан халаагуур худалдан авахад дэмжлэг үзүүлэх, хүү багатай зээлийн бүтээгдэхүүн бий болгох.

4.3. Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.3.1. хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа, стандартын шаардлага хангахгүй автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг үе шаттайгаар хориглох;

4.3.2. “Евро-5” стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулах, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах;

4.3.3. тээврийн хэрэгслийг хийн түлш, цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөө багатай техник, технологи, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх чиглэлээр судалгаа хийж турших, нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшинд үе шаттайгаар шилжүүлэх;

4.3.4. авто замын сүлжээг өргөтгөж, хөдөлгөөн зохицуулалтын ухаалаг систем нэвтрүүлэх, нийтийн тээврийн чанар, хүртээмжийг сайжруулж, автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах;

4.3.5. зам, тээврийн салбарын хог хаягдлын зохистой менежментийн судалгаа хийж, ашиглалтаас хасагдсан автомашины хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах;

4.3.6. хот хоорондын авто замын дагуу зорчигч, тээвэрлэгчийн ая тухыг хангасан ногоон шийдэлтэй түр буудаллах үйлчилгээний цогцолборыг төлөвлөн байгуулах;

4.3.7. авто замын ус зайлуулах системийг иж бүрнээр төлөвлөн хэрэгжүүлж, авто замын тоосыг зориулалтын машин, техникээр цэвэрлэх, замын цас, мөсийг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө багатай бодис ашиглан цэвэрлэж хэвшүүлэх.

4.4. Агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт, санхүүжилтийг тодорхой болгож, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг урамшуулах тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.4.1. “Агаарын бохирдлын эсрэг сан” байгуулж, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулах төсөв, хөрөнгийг төвлөрүүлэн сангийн хөрөнгийг агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээнд зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

4.4.2. агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх чиглэлээр албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, байгаль орчны хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллах;

4.4.3. бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдийг хөгжүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулах;

4.4.4. хот байгуулалт, ногоон байгууламжтай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

4.4.5. “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

4.4.6. эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

4.4.7. хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй, хэмнэлттэй, агаар, орчны бохирдлыг бууруулах болон цэвэрлэх дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн дотооддоо үйлдвэрлэхэд чиглэсэн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт үзүүлэх;

4.4.8. “Хийн хангамжийн мастер төлөвлөгөө” боловсруулан мөрдүүлэх;

4.4.9. насжилт ихтэй автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн импортыг үе шаттайгаар хязгаарлах, цахилгаан болон хийгээр ажилладаг автомашины хэрэглээг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

4.5. Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.5.1. агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд бодитой мэдээлэл өгч, зөв дадал хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

4.5.2. байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэх хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх;

4.5.3. гэр хорооллын нутаг дэсвэрт агаарын бохирдлын хяналт явуулж, хог хаягдал шатаах явдлыг зогсоож, энэ чиглэлээр зорилтот бүлэгт дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.5.4. агаар, орчны бохирдлыг бууруулахад идэвх, санаачилгатай, дэмжиж ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, хөхиүлэн дэмжих, үйл ажиллагааг нь сурталчлах;

4.5.5. агаар, орчны бохирдлын улмаас хүний эрүүл мэндэд учруулж байгаа урт болон богино хугацааны сөрөг нөлөөллийг тандан судалж, эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга барилыг төлөвшүүлж, агаар, орчны бохирдлын улмаас үүсэх өвчлөлийг бууруулах;

4.5.6. гэр, байр, орон сууцны доторх агаарын бохирдлыг бууруулах, арилгахад чиглэсэн зөвлөмж гаргаж, олон нийтэд сурталчлах;

4.5.7. байгаль орчны төв лаборатори болон орон нутгийн лабораторийг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн шинэчилж, бенз(а)пирен, дэгдэмхий органик нэгдэл зэрэг хорт бодис, хүнд металл тодорхойлох орчин үеийн мэдрэмж сайтай аналитик багаж, тоног төхөөрөмжөөр хангах;

4.5.8. агаар, орчны чанарын хяналтыг өргөжүүлэн энэ чиглэлийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх,

4.5.9. хот, суурин газарт агаарын бохирдлыг хянах суурин автомат харуулын тоог нэмэгдүүлж, тасралтгүй ажиллагааг нь хангах;

4.5.10. агаар, орчныг бохирдуулж байгаа эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж, бүртгэл, мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэх;

4.5.11. дуу чимээ, цахилгаан соронзон долгион зэрэг физикийн сөрөг нөлөөллийн төлөв байдлын судалгаа хийж, хяналтын тогтолцоог бий болгох.

Тав. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байгальд ээлтэй инженерийн дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг сайжруулж, агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрийг багасган дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрсийг хязгаарлаж, агаар, орчны бохирдлыг 80 хувиар бууруулна.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2016 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг явц болон үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин (он)			Хэрэгжүүлэх байгууллага	
			2016	2019	2025		
1.	Бохирдуулах бодисын бууралт (суурь үзүүлэлт 2016 оны 12 дугаар сарын дундаж)	PM2.5 тоосонцор	мкг/м ³	256	190	70	БОАЖЯ, НЗД
		PM10 тоосонцор	мкг/м ³	279	210	100	БОАЖЯ, НЗД
		Хүхэрлэг хий (SO ₂)	мкг/м ³	89	70	50	БОАЖЯ, НЗД
2.	Шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтөд хамрагдах нөхцөл бүрдсэн гэр хорооллын хэрэглэгч	тоо	110 895	135 000	150 000	ЭХЯ, ЭХЗХ	
3.	2.5 кВт-ын чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломж бүрдүүлэх өрх	тоо	20 000	110 000	-	ЭХЯ	
4.	4 кВт-ын чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломж бүрдүүлэх өрх	тоо	3 000	20 000	80 000	ЭХЯ	
5.	Цахилгаан эрчим хүчинд шинээр холбогдсон өрх	тоо	-	5 800	-	ЭХЯ	
6.	Түүхий нүүрсний хэрэглээг халж, сайжруулсан түлш хэрэглэх өрх	тоо	150	23 000	43 000	НЗД, ЭХЯ	
7.	Сайжруулсан түлшний үйлдвэрлэлийн хэмжээ	тн/жил	500	90 000	150 000	ЭХЯ, УУХҮЯ	
8.	Хэрэглэгчийг инженерийн төвлөрсөн хангамжид шилжүүлж, буулгасан халаалтын зуух	тоо	-	123	228	ЭХЯ, НЗД	
99.	Алслагдсан дүүрэг, орон нутаг руу шилжсэн хүн	тоо	-	2 000	9 600	НЗД, ҮСХ	
10.	Алслагдсан дүүрэг, орон нутагт бий болсон ажлын байр	тоо	-	1 000	10 000	ХХААХҮЯ, ХНХЯ, ҮСХ, АНЗД	
111.	Дэмжлэг авсан зорилтот бүлгийн өрх	тоо	-	13 300	13 000	НЗД, БОАЖЯ, ХНХЯ	

112.	Инженерийн дэд бүтцийн бичил дэд төв		тоо	-	20	100	БХБЯ, НЗД
113.	Инженерийн шугам сүлжээнд холбогдох техникийн боломж бүрдүүлэх гэр хорооллын өрх		тоо	20 000	40 000	70 000	БХБЯ, ЭХЯ, НЗД
114.	Гэр хорооллын айл өрхийн орон сууцны хангамж, орон сууцанд шилжин орсон айл өрх		тоо	-	20 000	70 000	БХБЯ, НЗД
115.	Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдсан хүн ам		хувь	38	43	50	БХБЯ, АНЗД
116.	Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдсан хот суурин газрын хүн ам		хувь	40	60	80	БХБЯ, АНЗД
117.	Хийн түлшээр ажиллах автотээврийн хэрэгсэл	Такси	тоо	312	1 000	3 000	ЗТХЯ, НЗД
		Автомашин	тоо	14 500	17 000	25 000	
118.	“Евро-5” стандартад нийцсэн шатахууны эзлэх хувь	Авто бензин	хувь	-	50	80	ЗТХЯ, УУХҮЯ, АМГТГ
		Дизель түлш	хувь	-	50	80	
119.	Цахилгаанаар халаах боломжтой нийт суудлын галт тэрэг		тоо	16	72	159	ЗТХЯ, ЭХЯ, НЗД
220.	Хог хаягдлыг боловсруулж эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр		тоо	-	-	1	ЭХЯ, НЗД
221.	Амьсгалын тогтолцооны өвчний бууралт (10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)		про-милль	456	448	433	ЭМЯ
222.	Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн бууралт (10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)		про-милль	399	393	384	ЭМЯ
223.	Уушигны хатгалгаа (10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)		про-милль	239	206	146	ЭМЯ
224.	Гэр хорооллын болон нийтийн эзэмшлийн нэмж зүлэгжүүлсэн талбай		га	110	1 450	3 000	НЗД
225.	Хот, суурин газрын ногоон байгууламжит талбайн эзлэх хувь	Улаан-баатар хот	хувь	1	7	25	НЗД
		аймаг	хувь	1	5	25	АЗД

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, ажлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 6.1.2. агаар бохирдуулсны төлбөрийн орлого;
- 6.1.3. ус бохирдуулсны төлбөрийн орлого;
- 6.1.4. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;
- 6.1.5. аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;
- 6.1.6. бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

- 7.1. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо гүйцэтгэнэ.
- 7.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг бүх шатны Засаг дарга Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран гүйцэтгэнэ.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

- 8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг жил бүр Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран гүйцэтгэнэ.
- 8.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 8.3. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт танилцуулна.
- 8.4. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль,

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 2 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 43

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Агаарын тухай хуулийн 6.1.5, 6.1.7, 6.1.9-6.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2018 оны 2 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1. Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дараах байгууллага, албан тушаалтанд даалгасугай:

1.1. нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар бүсчлэн хориглох арга хэмжээ авч, сайжруулсан түлшний хэрэглээг дэмжих, халаалтын бага, дунд, том оврын зуухнуудад эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийн шинэчлэлт хийх, халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажлыг 2018 онд багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.2. гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулахад шаардлагатай нийгмийн болон инженерийн дэд бүтэц, шугам сүлжээг бий болгож, барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх, инженерийн хангамжийн “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламж болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарыг татан оролцуулах замаар нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.3. зах зээл дээр борлогдоогүй байгаа орон сууцны талаарх судалгааг нарийвчлан гаргаж, тэдгээрийг эргэлтэд оруулах арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл, малчид, төрийн албан хаагчдыг орон сууцжуулах зорилттой уялдуулан хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.4. улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр баригдсан бөгөөд бүрэн ашиглалтад оруулж чадаагүй “ДЦС-2” ТӨХК-ийн дэргэдэх сайжруулсан түлшний үйлдвэрийг түшиглэн нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр хангах бие даасан аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газрыг байгуулах асуудлыг судалж, саналаа 2018 оны 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т;

1.5. эрчим хүчний хэмнэлттэй ахуйн цахилгаан халаагуур, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах иргэдэд зориулсан бага хүүтэй, урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх асуудлыг судалж, саналаа 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, амины орон сууцны байшин, гэрийн дулааны алдагдлыг бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх санал, санаачилгыг дэмжиж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.6. эрчим хүчний хэмнэлт, дулааны алдагдалгүй хэрэглээ, ногоон худалдан авалтыг дэмжин иргэд, байгууллагын хандлагыг өөрчлөх замаар агаар, орчны бохирдлыг бууруулах, олон нийтийн оролцоог хангасан “Бид нэг агаартай” аяныг тогтмол зохион байгуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.7. нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн түлшний хэрэглээнд үе шаттайгаар шилжүүлэх, Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд Тусгай замын автобус (BRT) системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт;

1.8. нийтийн тээврийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан 24 болон түүнээс дээш суудалтай, 48 болон түүнээс дээш зорчигчийн багтаамжтай, үйлдвэрлэгдсэн оноос хойш нэг хүртэл жилийн дотор импортоор оруулж ирэх цахилгаан тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг автобус, троллейбус, такси үйлчилгээнд зориулан тусгайлан үйлдвэрлэсэн автомашиныг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж, 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээвэр хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт;

1.9. үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд дотооддоо автобус, троллейбус үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт;

1.10. Улаанбаатар хотын дагуул хот, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт, дагуул хот, дэд төв, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхийг

Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.11. гэр хорооллын суурьшлын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийн дэд төвүүд барьж байгуулахтай холбогдуулан стандарт боловсруулж батлуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.12. хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байгуулах асуудлыг судалж, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт;

1.13. 2018 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын бүтцэд агаарын чанарт хяналт тавих үүрэг бүхий нэгжийг шинээр байгуулж, шаардагдах зардлыг батлагдсан төсвийн багцдаа зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд; 1.14. нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх хууль тогтоомж, журмын хэрэгжилтэд тавих хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж, явц, дүнг улирал тутам Засгийн газарт танилцуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.15. аймаг, нийслэл, сум, дүүрэгт харьяа нэгжтэй Засгийн газрын зарим агентлаг болон төрийн байгууллага, төрийн өмчит их, дээд сургуулиудыг хотын төвөөс нүүлгэн шилжүүлэх асуудлыг судалж, саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.16. Улаанбаатар хотын дагуул хот, тосгон болон нүүлгэн шилжүүлэх их, дээд сургуулиудын хотхоныг холбох хурдны зам, дэд бүтэц байгуулах асуудлыг судалж, холбогдох тооцоо, судалгаа бүхий саналыг 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.17. иргэдийн орлогод нийцсэн хямд өртөгтэй орон сууц болон түрээсийн орон сууц барихад шаардагдах хөрөнгийг зориулалтын сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.18. нийслэлээс орон нутагт шилжин суурьшиж мал аж ахуй, газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдийг дэмжин ажлын байраар хангах, урамшуулах асуудлыг судлан, тодорхой санал боловсруулж 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

1.19. иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчин агаар, орчныг бохирдуулж байгаа үйлдэлд хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, 2018 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт оруулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл нарт.

2. Хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн тооцоог хийж 2018 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Байгаль орчин, аялал

жуулчлалын сайд

Н.ЦЭРЭНБАТ

